



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймаг дахь МСҮТ-н 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БУА-2022/112/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Булган хот 2022 он</p>	<p>Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас: 70342580 Цахим хаяг: ankhbayard@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: enhtsoodolj@audit.gov.mn</p> <p>Аудитор: Б.Пүрэвсүрэн Утас: 70353717 Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2-3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
3. Аудитын тайлан	12
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХАА	Хөдөө аж ахуй

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-3259
E-mail: bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 30

танай _____ ны № _____ т

МЭРГЭЖИЛ СУРГАЛТ
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН
ЗАХИРАЛ Д.БАТТУЯА ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

D:/bichighereg/2022A4foot

006020047

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Д.АНХБАЯР

D:/bichighereg/2022A4toot

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>129,654,182.69</u>	<u>260,237,880.75</u>
33	АВЛАГА	<u>7,699,147.80</u>	<u>3,510,701.28</u>
335	Бусад авлага	<u>7,699,147.80</u>	<u>3,510,701.28</u>
3351	Байгууллагаас авах авлага	<u>7,694,304.80</u>	<u>3,496,697.28</u>
3352	Хувь хүмүүсээс авах авлага	<u>4,843.00</u>	<u>14,004.00</u>
34	УРЬДЧИЛГАА	<u>4,823,781.00</u>	<u>4,823,781.00</u>
3471	Урьдчилгаа тооцоо	<u>4,823,781.00</u>	<u>4,823,781.00</u>
34713	Цалингийн урьдчилгаа	<u>4,823,781.00</u>	<u>4,823,781.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	117,131,253.89	251,903,398.47
351	Түүхий эд материал	5,468,300.00	4,586,080.00
35110	Тусгай зориулалттай материал	698,000.00	395,000.00
35130	Эм боох материал	4,770,300.00	4,191,080.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	6,019,990.00	7,084,349.00
354	Хангамжийн материал	105,642,963.89	240,232,969.47
35410	Бичиг хэргийн материал	3,089,980.00	2,582,150.00
35420	Аж ахуйн материал	92,020,955.98	196,279,129.00
35430	Сэлбэг хэрэгсэл	176,000.00	38,676,000.00
35440	Түлш, шатах тослох материал	432,985.91	236.00
35450	Барилгын засварын материал	5,826,800.00	1,353,000.00
35460	Хүнсний материал	4,043,492.00	1,289,704.47
35470	Бусад хангамжийн материал	52,750.00	52,750.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,235,108,066.28</u>	<u>3,040,654,912.47</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,235,108,066.28	3,040,654,912.47
392	Биет хөрөнгө	2,946,871,608.63	2,754,351,954.94
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,668,358,471.93	2,668,358,471.93
39202	Хуримтлагдсан элэгдэл	(187,690,972.68)	(281,536,459.08)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	30,268,000.00	16,400,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(24,246,065.74)	(12,684,732.74)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	871,370,898.56	221,232,678.42
39206	Хуримтлагдсан элэгдэл	(638,188,847.31)	(69,628,648.75)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	80,483,281.50	10,797,900.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(72,321,250.61)	(8,049,243.32)
39209	Зам гүрийн барилга байгууламж	265,000.00	265,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	235,905,668.00	227,546,790.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(39,630,676.02)	(41,988,118.52)
39217	Ном	22,298,101.00	23,638,317.00
393	Биет бус хөрөнгө	288,236,457.65	286,302,957.53
39301	Программ хангамж	19,441,950.00	15,710,000.00
39302	Хасагдуулаг	(12,795,492.35)	(10,997,042.47)
39303	Бусад биет бус хөрөнгө	281,590,000.00	281,590,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,364,762,248.97</u>	<u>3,300,892,793.22</u>
	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	<u>7,699,147.80</u>	<u>626,185.00</u>

	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	<u>7,699,147.80</u>	<u>626,185.00</u>
413	Өглөг	<u>7,699,147.80</u>	<u>626,185.00</u>
4131	Ажиллагчидтай холбогдсон өглөг		
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг		<u>609,906.00</u>
4136	Бусад өглөг	<u>7,699,147.80</u>	<u>16,279.00</u>
41361	Байгууллага төлөх өглөг	<u>4,843.00</u>	
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	<u>7,694,304.80</u>	<u>16,279.00</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3,357,063,101.17</u>	<u>3,300,266,608.22</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	3,357,063,101.17	3,300,266,608.22
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,583,289,990.50	1,583,289,990.50
51101	Өмч: - төрийн	1,583,289,990.50	1,583,289,990.50
512	Хуримтлагдсан үр дүн	264,766,215.07	207,969,722.12
51210	Өмнөх үеийн үр дүн	264,766,215.07	264,766,215.07
51220	Тайлант үеийн үр дүн	-	(56,796,492.95)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,509,006,895.60	1,509,006,895.60
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>3,364,762,248.97</u>	<u>3,300,892,793.22</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,369,011,744.00	1,646,162,330.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16,452,344.00	209,222,030.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,995,355.00	209,222,030.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,995,355.00	209,222,030.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,971,073.00	9,331,441.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	24,282.00	199,890,589.00
	Тусламжийн орлого	14,456,989.00	
122001	Хандив тусламж /дотоод/	14,456,989.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,352,559,400.00	1,436,940,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,352,559,400.00	1,436,940,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,352,559,400.00	1,436,940,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,710,532,216.13	1,664,131,073.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,710,532,216.13	1,664,131,073.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,588,645,418.68	1,491,485,568.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	773,586,075.84	803,732,101.97
210101	Үндсэн цалин	440,668,905.16	490,304,629.96
210102	Нэмэгдэл	263,200,024.68	253,076,041.21
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21,095,000.00	21,685,679.80
210104	Урамшуулал	48,622,146.00	38,665,751.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	95,497,194.80	102,650,081.63
210201	Тэтгэврийн даатгал	72,843,565.31	71,322,081.63

210202	Тэтгэмжийн даатгал	8,093,859.28	7,832,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,385,055.72	6,265,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,463,981.00	1,566,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,710,733.49	15,664,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	282,768,167.07	308,643,587.72
210301	Гэрэл, цахилгаан	6,412,179.07	3,826,019.72
210302	Түлш, халаалт	268,071,871.00	292,442,040.00
210303	Цэвэр, бохир ус	8,284,117.00	12,375,528.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,904,841.59	58,088,481.89
210401	Бичиг хэрэг	2,825,850.00	2,108,045.00
210402	Тээвэр, шатахуун	3,385,206.59	1,971,249.91
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,505,800.00	2,722,770.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,333,900.00	3,012,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,301,300.00	3,246,050.00
210408	Бараа материал акталсны зардал	552,785.00	45,027,766.98
2105	Норматив зардал	9,168,331.00	9,778,599.22
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,361,050.00	222,020.00
210502	Хоол	7,766,481.00	7,487,679.22
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	40,800.00	2,068,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,168,100.00	13,930,600.00
210601	Багаж хэрэгсэл	262,500.00	
210604	Урсгал засвар	6,905,600.00	13,930,600.00
2107	Томилолт, зочны зардал	127,000.00	127,000.00
210702	Дотоод албан томилолт	127,000.00	127,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,109,128.00	2,118,623.50
210803	Даатгалын үйлчилгээ	665,340.00	1,258,010.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	117,600.00	81,517.50
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	77,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	242,000.00	742,500.00
210807	Газрын төлбөр	7,188.00	3,596.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	398,316,580.38	192,416,493.03
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	20,914,407.34	21,333,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	377,402,173.04	171,083,493.03
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	121,886,797.45	172,645,504.21
2132	Бусад урсгал шилжүүлэг	60,380,800.00	144,812,653.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	27,846,400.00	94,246,453.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	31,149,400.00	49,444,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,385,000.00	1,122,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	61,505,997.45	27,832,851.21
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	61,505,997.45	27,832,851.21

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(341.520.4726.13)</u>	<u>(17,968,743.17)</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		38,827,749.78
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		38,827,749.78
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		(38,827,749.78)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(341,520,472.13)</u>	<u>(56,796,492.95)</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,301,699,990.50	815,671,224.54	800,175,575.09	2,917,546,790.13
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,301,699,990.50	815,671,224.54	800,996,575.09	2,918,367,790.13
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Тайлант үеийн үр дүн				
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,583,289,990.50	1,509,006,895.60	264,766,215.07	3,357,063,101.17
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,583,289,990.50	1,509,006,895.60	264,766,215.07	3,357,063,101.17
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,583,289,990.50	1,509,006,895.60	264,766,215.07	3,357,063,101.17

Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
Тайлант үеийн үр дүн			(56,796,492.95)	(56,796,492.95)
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,583,289,990.50	1,509,006,895.60	207,969,722.12	3,300,266,608.22

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,354,730,473.00</u>	<u>1,446,271,741.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,171,073.00	9,331,441.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,171,073.00	9,331,441.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,171,073.00	9,331,441.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,171,073.00	9,331,441.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,352,559,400.00	1,436,940,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,352,559,400.00	1,436,940,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,352,559,400.00	1,436,940,300.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,354,730,473.00</u>	<u>1,446,271,741.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,354,730,473.00	1,446,271,741.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,232,843,675.55	1,273,626,236.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	768,534,338.00	800,240,799.26
210101	Үндсэн цалин	517,829,668.81	486,813,327.25
210102	Нэмэгдэл	187,888,340.50	253,076,041.21
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,613,941.07	21,685,679.80

210104	Урамшуулал	39,202,387.62	38,665,751.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	95,402,563.64	102,567,378.03
210201	Тэтгэврийн даатгал	64,074,663.64	71,239,378.03
210202	Тэтгэмжийн даатгал	7,831,900.00	7,832,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,265,600.00	6,265,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,566,400.00	1,566,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	15,664,000.00	15,664,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	282,768,167.07	311,528,100.00
210301	Гэрэл, цахилгаан	6,412,179.07	3,826,019.72
210302	Түлш, халаалт	268,071,871.00	295,936,458.28
210303	Цэвэр, бохир ус	8,284,117.00	11,765,622.00
210304	Байрны түрээс		
2104	Хангамж, бараа материалын зардал	28,185,567.50	11,369,485.00
210401	Бичиг хэрэг	2,181,700.00	1,866,295.00
210402	Тээвэр, шатахуун	3,741,785.00	1,538,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,368,300.00	2,722,770.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	14,176,890.00	3,012,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,716,892.50	2,229,320.00
2105	Норматив зардал	13,187,670.00	11,342,302.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,467,300.00	323,200.00
210502	Хоол хүнс	8,841,220.00	8,307,902.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,879,150.00	2,711,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,163,900.00	10,987,200.00
210601	Багаж техник хэрэгсэл	6,899,500.00	1,346,400.00
210604	Урсгал засвар	10,264,400.00	9,640,800.00
2107	Томилолт, зочны зардал	127,000.00	127,000.00
210702	Дотоод албан томилолт	127,000.00	127,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,109,128.00	2,118,623.50
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		
210803	Даатгалын үйлчилгээ	665,340.00	1,258,010.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	117,600.00	81,517.50
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	77,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	242,000.00	742,500.00
210807	Газрын төлбөр	7,188.00	3,596.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,365,341.34	23,345,349.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	26,365,341.34	23,345,349.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	121,886,797.45	172,645,504.21
2132	Бусад урсгал шилжүүлэг	60,380,800.00	144,812,653.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	27,846,400.00	94,246,453.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	31,149,400.00	49,444,200.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,385,000.00	1,122,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	61,505,997.45	27,832,851.21
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	61,505,997.45	27,832,851.21
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,456,940,300.00	1,418,438,889.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,456,940,300.00	1,418,438,889.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,312,127,200.00	1,273,626,236.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	807,287,300.00	800,240,799.26
210101	Үндсэн цалин	518,156,200.00	486,813,327.25
210102	Нэмэгдэл	207,197,900.00	253,076,041.21
210103	Унаа хоолны хөнгөлөлт	37,422,000.00	21,685,679.80
210104	Урамшуулал	44,511,200.00	38,665,751.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	104,856,900.00	102,567,378.03
210201	Тэтгэврийн даатгал	73,528,900.00	71,239,378.03
210202	Тэтгэмжийн даатгал	7,832,000.00	7,832,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,265,600.00	6,265,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,566,400.00	1,566,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	15,664,000.00	15,664,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	317,278,100.00	311,528,100.00
210301	Гэрэл, цахилгаан	7,207,000.00	3,826,019.72
210302	Түлш, халаалт	298,192,000.00	295,936,458.28
210303	Цэвэр, бохир ус	11,879,100.00	11,765,622.00
210304	Байрны түрээс		
2104	Хангамж, бараа материалын зардал	11,967,800.00	11,369,485.00
210401	Бичиг хэрэг	1,866,300.00	1,866,295.00
210402	Тээвэр, шатахуун	1,538,500.00	1,538,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,319,500.00	2,722,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,013,200.00	3,012,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,230,300.00	2,229,320.00
2105	Нормативт зардал	33,267,400.00	11,342,302.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	323,200.00	323,200.00
210502	Хоол хүнс	30,230,000.00	8,307,902.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,714,200.00	2,711,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,987,200.00	10,987,200.00

210604	Багаж техник хэрэгсэл	1,346,400.00	1,346,400.00
210604	Урсгал засвар	9,640,800.00	9,640,800.00
2107	Томилолт, зочны зардал	127,000.00	127,000.00
210702	Дотоод албан томилолт	127,000.00	127,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,843,100.00	2,118,623.50
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		
210803	Даатгалын үйлчилгээ	1,915,000.00	1,258,010.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	82,000.00	81,517.50
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	100,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	742,500.00	742,500.00
210807	Газрын төлбөр	3,600.00	3,596.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,512,400.00	23,345,349.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	23,512,400.00	23,345,349.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	144,813,100.00	144,812,653.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	144,813,100.00	144,812,653.00
213206	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	94,246,500.00	94,246,453.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	49,444,200.00	49,444,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,122,400.00	1,122,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,456,940,300.00	1,446,271,741.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,436,940,300.00	1,436,940,300.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,436,940,300.00	1,436,940,300.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	20,000,000.00	9,331,441.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,000,000.00	9,331,441.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	61	61
620001	Удирдах ажилтан	3	3
620002	Гүйцэтгэх ажилтан	33	33
620003	Үйлчлэх ажилтан	25	25
632	МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ	1	1
632001	Төрийн өмчит МСҮТ	1	1
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	61	61
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	39	39
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	22	22

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь “Бейкер Тилли Далайван аудит” ХХК-ийн аудитор Б.Пүрэвсүрэн гүйцэтгэж, эхний шатны хяналтыг ахлах аудитор, захирал Д.Мягмарсүрэн хэрэгжүүлж, 2 болон 3-р шатны хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, Орхон аймгийн төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Булган аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв нь иргэний сонирхол, авьяас, чадварыг харгалзан хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжил олгох, техникийн боловсрол эзэмшүүлэх, ур чадварыг нь дээшлүүлэх үйл ажиллагаа явуулдаг.

Тайлант оны хичээлийн жилд " Судалгаа шинжлэлт, шинэ санаа инновацыг дэмжин хөгжүүлэх замаар баялаг бүтээгч, чадварлаг иргэнийг төлөвшүүлнэ " зорилго дэвшүүлж, хэрэгжилтийг хангах дараах зорилт дэвшүүлсэн байна.

- Чадамжид суурилсан сургалтын арга зүй, үнэлгээний тогтолцоог бүрдүүлэх
- Суралцагчийн эрхийг нэн тэргүүнд тавьж сурах, хөгжих, хамгаалуулах, оролцох эрхийг баталгаажуулж нийгмийн ажилтны мэргэжлийн үйлчилгээг үзүүлж ажиллах.
- Нийгмийн түншлэгч, ажил олгогч, мэргэжлийн холбоодын үүрэг оролцоог нэмэгдүүлэн харилцан үр дүнтэй хамтран ажиллах.
- Багш, ажилтан, суралцагчдын эрүүл мэнд, нийгмийн хамгааллыг дэмжих, хүний нөөцийг чадавхжуулах
- Чадамжид суурилсан сургалтын орчинг сайжруулах

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “ дунд ” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 1,451,190.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 14,511.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 10,158.33 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Булган аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 63,869.45 мянган төгрөгөөр буюу 1.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	12,522.92	8,334.48	(4,188.44)
Бараа материал	117,131.20	251,903.39	134,772.1
Үндсэн хөрөнгө	3,235,108.06	3,040,654.91	(194,453.15)
Нийт хөрөнгө	3,364,762.24	3,300,892.79	(63,869.45)
Өр төлбөр	7,699.14	626.18	(7,072.96)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,357,063.10	3,300,266.60	(56,796.50)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,364,762.24	3,300,892.79	(63,869.45)

Бараа материалын данс 251,903.39 мянган төгрөг болж 134,772.10 мянган төгрөгөөр өссөн эд хөрөнгө, бараа материалын тооллого хийж бүртгэлтэй тулгаж баталгаажууллаа. Мөн Булган МСҮТ-н үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй байсан ашиглалтын хугацаа дуусаж үлдэх өртөггүй хэвийн ажиллагаатай 180 нэр төрлийн 836 ширхэг хөрөнгийг үнэ бууруулан 145,932.5 төгрөгөөр аж ахуйн дансанд орлого авсан. Захирлын 2021 оны 03 сарын 12-ны өдрийн А/23, 09 сарын -ны өдрийн А/ тоот тушаалуудаар аж ахуйн материалын данснаас ашиглах боломжгүй, эвдэрсэн засаж сэлбэх боломжгүй 45,027.76 төгрөгийн хөрөнгүүдийг акталж данснаас хассан

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,040,654.91 мянган төгрөг болж 194,453.15 мянган төгрөгөөр буурсан нь 2021 оны 05 сард Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас 42 нэр төрлийн 496 ширхэг 1,340.22 төгрөгийн хичээл сургалтанд ашиглах ерөнхий эрдмийн болон

мэргэжлийн номуудыг тус тус хүлээн авч данс бүртгэлд тусгасан. Мөн 4 нэр төрлийн 12 ширхэг 14,117.87 төгрөгийн машин тоног төхөөрөмжийг хүлээн авч бүртгэлд тусгасан. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 04 сарын 05-ны 100, 11 сарын 11-ны өдрийн 522 дугаар тогтоолоор тус тус элэгдлээ бүрэн нөхсөн ашиглах боломжгүй 424 нэр төрлийн 1721 ширхэг 759,900.3 төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хасаж 194,979.44 төгрөгийн 2 автомашин, 3 тракторыг 100 дугаар тогтоолын 2.2-т заасны дагуу өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар үнийг хэлэлцүүлэн эргэлтийн хөрөнгөнд 38500000 төгрөгөөр дахин орлогодож авсан болно. Түүнчлэн 586,056.79 төгрөгийн 180 нэр төрлийн 836 ширхэг хөрөнгийг өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар оруулан аж ахуйн дансанд 145,932.5 төгрөгөөр орлого авч бүртгэлд тусгасан.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,300,266.6 мянган төгрөг болж 56,796.50 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Булган аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого өмнөх оноос 277,150.58 мянган төгрөгөөр буюу 20.2 хувиар өссөн, нийт зардал өмнөх оноос 46,401.14 мянган төгрөгөөр буюу 2,7 хувиар буурсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Булган аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,422,997.20 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2,422,997.20 мянган төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагаас хүргүүлсэн төсвийн төслийг 951,996.1 мянган төгрөгөөр бууруулан 1,471,001.1 мянган төгрөгөөр баталсан байна. Тайлант онд төсвийг 2 удаа тодотгол хийж 14,060.80 мянган төгрөгөөр бууруулж, 1,456,940,3 мянган төгрөгөөр баталжээ. Цалингийн зардлыг бууруулж тодотгол хийсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх мэргэжлийн боловсрол хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр 1,436,940.30 мянган төгрөгийг улсын төсвөөс, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 9,331.44 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,418,438.88 мянган төгрөгийг зарцуулж, 27,832.85 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,418,438.88 мянган төгрөг буюу 97.3 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 7,046.5 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 2,289.5 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 5,750.0 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 598.3 мянган төгрөг, норматив зардлыг 21,925.09 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн зардлыг 724.5 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 167,05 мянган төгрөгийг дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. 2021 онд нэмэлт төсвийн санхүүжилт байхгүй болно.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудитын хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Булган аймаг дахь МСҮТ нь Шилэн дансанд 5, 8 сарын 9 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна. Мөн шилэн дансанд мэдээлэх мэдээллийн талаар талбар бүрээр зөвлөгөө өглөө.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 611.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 20,733.90 мянган төгрөгийг нийт 21,334.9 мянган төгрөгийн 6 зөвлөмжийн хэрэгжилтийг 100 хувьтай хангуулсан байна.

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	хувь
Акт	-	-	-	-	-	-	
Албан шаардлага	1	611,0	611,0	611,0	-	-	
Зөвлөмж	6	20,733.9	20,733.9	20,733.9	-	-	
Нийт дүн	7	21,344.9	21,344.9	21,344.9	-	-	

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал, урсгал засварын зардлын төлөвлөлт, гүйцэтгэл анхаарал татахаар бөгөөд бусад чухал асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 15,669.22 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 9,429.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 4,136.89 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 90.0 мянган төгрөгийн 1 акт, 2,013.23 мянган төгрөгийн алдаа зөрчилд 5 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Тайлант хугацаанд хог хаягдал устгах, цэвэрлэх зардал мөнгөн гүйлгээний тайланд 3,012.6 мянган төгрөг байхад 5,137.9 мянган төгрөгөөр үр дүн дээр зарлагдсан нь бараа материалын 2,135.3 мянган төгрөгийг залруулж, байр ашиглалтай холбоотой тогтмолыг зардлыг 10,178.31 мянган төгрөг байсныг 2,884.51 мянган төгрөг болгож 7,293.8 мянган төгрөгийг залруулсан нийт 9,429.1 мянган төгрөг байна.

4.2 Албан шаардлага

Тайлангийн хугацааны эцэст 3 510.7 мянган төгрөгийн авлагын 626.1 мянган төгрөгийн өглөгтэй үлдэгдэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь заалтын дагуу "төсвийг зохистой удирдаж өр авлага үүсгэхгүй байх" гэсэн заалтын дагуу авлага өглөг үүсгэхгүй байх заалтыг зөрчсөн байна.

Өгсөн албан шаардлага:

Холбогдох хууль тогтоомжийг баримтлан гаргасан тушаал, журмыг баримтлан үндэслэх баримт бичгийг бүрэн бүрдүүлж байх.

4.3 Акт

Анхан шатны баримтын иж бүрдэл дутуу е баримтгүй буюу хувь хүний сугалаатай анхан шатны баримтаар 90.0 мянган төгрөгийн гүйлгээ хийгдсэн байна. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтаар баталгаажсан байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн акт:

Цахим баримтаар гүйлгээг хийж хэвших, анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлэх.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Групптэй ажилчдын амралтын бодохдоо групптэй хүнд нэмж олгох 5 хоногийг нэмж амруулаагүй 5 хоногийн амралтын мөнгийг ажилласан цалингаар бодож олгосон байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 99.4-т "Хөгжлийн бэрхшээлтэй болон 18 насанд хүрээгүй ажилтны ээлжийн үндсэн амралтын хугацаа ажлын 20 өдөр байна" гэсэн заалтаар амралтын хоногийг нэмж биеэр амрааж амралтын мөнгийг тооцож олгох заалттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Холбогдох хууль тогтоомжийг баримтлан гаргасан тушаал, журмыг баримтлан үндэслэл болгон амралтын хоногийг өгөх.

2. Орлогын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тухайн байгууллагын спорт заал, үйлдвэр сургалтаар гарсан бүтээгдэхүүний борлуулалтын орлогыг нотлох баримтын иж бүрдэл дутуу мэргэжлийн ангиуд тус бүртээ олж буй өөрийн орлогын тайлан хангалтгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх," Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.5-д "Нягтлан бодох бүртгэлд бүх орлогыг заавал бүртгэнэ" заалтын дагуу өөрийн орлогыг үнэн зөв тодорхойлж бүртгэлд тусгах заасныг мөрдөөгүйтэй холбоотой байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Үндсэн бус үйл ажиллагааны орлогыг борлуулалт хийсэн тухай бүр орлогыг хэрхэн цуглуулж төвлөрүүлэн, санхүүгийн тайлангийн тодруулга тайлбар хэсэгт тайлагнах.

3. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Хичээл үйлдвэрлэлийн зардлаас гарсан материалаар хийгдэж буй бүтээлийг няравт хүлээлгэн өгсөн баримт байхгүй. Нярав бүтээлийг худалдсан, ашигласан, хаягдал болсон зэргийг тусгасан нярвын бүртгэл, тайлан байхгүй байна. Энэ нь Няравын ажлын байрны тодорхойлолтыг тодорхой зааж, өөрийн байгууллагын онцлог бүхий бүртгэл тайлан бүртгэл хөтлөлтийг хийж хэвших хүрээнд шалгасан зүйлийн холбогдох шалгуурт нийцэхгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Бараа материалын тайлан болон нярвын бүртгэлтэй тулган баталгаажуулах

4. Шилэн дансны хэрэгжилттэй холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Шилэн дансанд 5, 8 сарын 9 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх; 4.1.3."тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалтын дагуу хугацаанд нь мэдээлж байх заасныг мөрдөөгүйтэй холбоотой байна.

4.2. Өгсөн зөвлөмж:

Байгууллагын шилэн дансны мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн мэдээлж, дотоод хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх, хариуцлагыг сайжруулах.

5. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

5.1. Илрүүлэлт:

Сургалтын менежер Т.Солонгод чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр, техникийн боловсролын сургалтын хөтөлбөр боловсруулж баталгаажуулах ажлын үнэлгээ нэг багт 1 багц цагаар тооцохыг нэг хүнд бүтэн 1 багц цагаар тооцон 1 680.0 мянган төгрөгийг илүү бодож олгосон. Энэ нь Сангийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2019 оны 12 сарын 26-ны өдрийн 289/А375 тоот тушаалаар батлагдсан "Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багшийн сургалтын ажлыг багц цагаар тооцох журам"-ын 2 дугаар хавсралтын 7-д заасан тооцох багц цагаар бодож олгохтой нийцэхгүй байна

5.2. Өгсөн зөвлөмж:

Холбогдох хууль тогтоомжийг баримтлан гаргасан тушаал, журмыг баримтлан үндэслэл болгон олгож байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/


д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Булган аймаг дахь МСҮТ	9	15,669.22	2	9,429.1	1	90.0	1	4,136.89	5	2,013.23
	Дүн	9	15,669.22	2	9,429.1	1	90.0	1	4,136.89	5	2,013.23

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:

"БЕЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ" ХХК-ИЙН ОРХОН АЙМАГ ДАХЬ САЛБАРЫН


АУДИТОР:



Б.ПҮРЭВСҮРЭН

ХЯНАСАН:

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР, ЗАХИРАЛ:



Д.МЯГМАРСҮРЭН

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

АУДИТЫН МЕНЕЖЕР:



Ж.ЭНХЦООДОЛ

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Д.АНХБАЯР